

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
МЭРГЭЖИЛТЭН С.ОЮУНДОЛГОРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1.1 “Төсвийн орлогын төслийг боловсруулах, хуваарилах, хэрэгжилтийг хангуулах болон төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх”							
1.	Арга хэмжээ 1.1.1 Төсвийн орлогыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, хуваарилах, биелэлтэнд хяналт тавих, Сар бүр татварын байцаагчтай орлогын мэдээг тулган баталгаажуулж, гүйцэтгэлд хяналт тавих	Төсвийн орлого бүрдүүлэлт	8,2 тэрбум төгрөг Эх сурвалж: *uvurkhangai.mn.	Эхний хагас жилд: 2,9 тэрбум төгрөг	Аймгийн орон нутгийн төсвийн орлого 2025 оны 05 сарын байдлаар 2,6 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 2,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байна. Орлогын төлөвлөгөөний биелэлт 103,1 хувь буюу 3,1 хувиар давж биелсэн. Сумын орон нутгийн татварын орлого 2025 оны 05 сарын байдлаар 16,3 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 17,2 тэрбум төгрөг төвлөрсөн. Орлогын төлөвлөгөөний биелэлт 105,1 хувь буюу 5,1 хувиар давж биелсэн. Мөн 2024 оны Нохойны албан татвар төвлөрүүлээгүй 4 сумдын санхүү албаны дарга нарт цахимаар үүрэг, чиглэл өгсөн.	2025-01-01 2025-06-05	100%
2.	Арга хэмжээ 1.1.2 Улс, аймаг, орон нутгийн төсвийн орлогын мэдээг шилэн данс болон uvurkhangai.mn сайтад хугацаанд нь мэдээлнэ	Мэдээний тоогоор	100%	100%	Шилэн дансны тухай хуулийн дагуу шинэчилсэн https://info.shilendans.gov.mn/ цахим хуудсанд сар бүр байршуулах ёстой 24	2025-01-01 2025-06-05	100%

					мэдээллээс хугацаа болсон 9 мэдээллийг хуулийн дагуу цаг хугацаанд нь ил тод болгон бүрэн мэдээлсэн. 15 мэдээлэл хугацаа болоогүй байгаа.		
Зорилт 1.2 “ Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг хэрэгжүүлэх”							
	Арга хэмжээ 1.2.1 Аж ахуй нэгж байгууллагын санхүүгийн тайланг НББОУС-ын дагуу цахим системээр хүлээн авч шалган баталгаажуулж хуулийн хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх	Жилийн эцсийн баталгаажсан тайлангийн тоо	1706	80%	2024 оны жилийн эцсийн байдлаар идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-10, Хоршоо-316, ТББ-130, ХЗХ-1, ААНБ-1249 нийт 1706 ААНБ санхүүгийн тайлан илгээхээс 1457 ААНБ цахим тайлангийн И-баланс системд санхүүгийн тайлангаа илгээж тухайн тайлангуудыг шалгаж баталгаажуулж сангийн яаманд хүргүүлсэн.	2025-01-01 2025-06-05	100%
	Арга хэмжээ 1.2.2 Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх, хууль зөрчсөн албан тушаалтан, байгууллагад хариуцлага хүлээлгэх	Зөрчлийн тоо	0	20	Хуулийн хугацаанд санхүүгийн тайлангаа илгээгээгүй 30 аж ахуйн нэгжийн нягтлан бодогчид Зөрчлийн тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ авч 12,0 сая төгрөгийг хүү торгуулийн орлогын дансанд төвлөрүүлсэн. 2024 онд шинээр байгуулагдаад жилийн эцсийн санхүүгийн тайлан илгээх талаар мэдлэггүй байсан 58 ААНБ-ын албан тоотыг авч сануулга, зөвлөгөө өгөн жилийн эцсийн тайланг нь хүлээн авч шалган баталгаажуулсан.	2025-01-01 2025-06-05	100%
	Арга хэмжээ 1.2.3 Орон нутгийн өмчид компаниудад холбогдох байгууллагуудтай хамтран зөвлөн туслах үйлчилгээ	ОНӨК-ын тоо	13	5	Аймгийн Засаг даргын А/168 дугаартай “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлийг сайжруулах, цахим системийг	2025-01-01 2025-06-05	100%

	үзүүлэх.				нэвтрүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай" захирамжийн дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. Орон нутгийн өмчит компаниудад танхим, цахим хосолсон 2 удаагийн сургалтыг зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгсөн.		
Зорилт 1.3 “ Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, хяналт тавих, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, сургалт сурталчилгаа зохион байгуулах”							
1	Арга хэмжээ 1.3.1 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулах өргөдөл хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, гэрчилгээ олгох	Хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэгчийн тоо	11	1	Шинээр мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэнээр бүртгүүлэх 2 иргэний хүсэлтийг цахимаар болон цаасаар хүлээн авч Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах ажлын хэсгийг хуралдуулан аймгийн Засаг даргын захирамж гаргуулан бүртгэж бүртгэлийн гэрчилгээ олгосон.	2025-01-01 2025-06-05	100%
2.	Арга хэмжээ 1.3.2 Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч нь мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжийг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих	Хуулийн дагуу үйл ажиллагаа эрхлэгчийн тоо	-		Аймгийн хэмжээнд мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч 13 иргэн байгаа бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, хууль зөрчсөн 2 иргэдийг дараагийн шатны хууль хяналтын байгууллагат шилжүүлсэн.	2025-01-01 2025-06-05	100%
3	Арга хэмжээ 1.3.3 Иргэдэд санхүүгийн боловсрол олгох, цахим санхүүгийн бүтээгдэхүүний, сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан иргэдийн тоо	500	200	Арвайхээр сумын цэргийн хүрээний 86 ахлагч нарт “Өрхийн төсөв, санхүүгийн боловсрол” сэдэвт сургалт, “Дэлхийн мөнгөний долоо хоног-2025” аяны хүрээнд Өвөрхангай аймаг дахь Монгол банкны хэлтэс, Насан туршийн суралцахуйн төвийн 19 сумын нэгж, Гүүд сек ҮЦК, Өсвөрийн санхүүч клуб зэрэг байгууллагуудтай хамтран нийт сурагчдын дунд 109 удаагийн сургалт, “Мэдлэгтэй хайрцаг” аяныг	2025-01-01 2025-06-05	100%

					байгууллагуудаар аялуулж 12 байгууллагын 218 албан хаагч, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран “Өрхийн төсөв, санхүүгийн боловсрол”, “Төсөл бичих аргачлал”, “Цахим ур чадвар” сэдвээр хэсэгчилсэн сургалтуудыг 2 удааг амжилттай зохион байгуулж нийт 37 иргэн тус тус хамрагдсан.		
4	Арга хэмжээ 1.3.4 Орон нутагт зохицуулалт бүхий үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын бүртгэл, судалгааг шинэчилэх, мэдээ тайланг нэгтгэх, СЗХороонд хүргүүлэх	Зохицуулалт тай салбарын тоо	6	2	Аймгийн ЗДТГ-ын албан ёсны цахим хуудсаар дамжуулан Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон Мөнгөн зээлийн бодлогын зөвлөлөөс тогтоосон зээлийн хүүний дээд хэмжээний талаар мэдээлэл хүргэснээр 17.000 хандалт, Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн газар дээрх хяналтын талаар мэдээлэл хүргэснээр 5.700 хандалттай байна. Үнэт эдлэлийн худалдаа эрхлэгч нарын судалгааг гарган 11 иргэнд СЗХ-с тусгай зөвшөөрөл авах талаар сургалт хийн мэдээлэл өгсөн	2025-01-01 2025-06-05	100%
Зорилт 1.4 “Хууль тогтоомж, тогтоол шийвдэр бодлогын баримт бичигт тусгагдсан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх”							
1	Арга хэмжээ 1.4.1 Файлын эмх цэгцийг сайжруулах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу баримтыг эмхлэн цэгцэлж, бүрэн бүрдэлтэй нь байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Байгууллагын архивт баримтыг бүрэн хүлээлгэн өгсөн байна	100%	100%	2024 онд Хэлтсийн 11 төрлийн нийт 29ш баримтыг стандартын дагуу эмхлэн цэгцэлж, үдэж дугаарлан байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. Энэ оны баримт үдэх хугацаа болоогүй.	2025-01-01 2025-06-05	100%

2	Арга хэмжээ 1.4.2 Хариуцсан албан тушаалийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хууль тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, салбарын яам агентлаг болон дээд шатны байгууллагад хүргүүлэх хугацаатай мэдээ, тайлан, судалгааг нэгтгэн хүргүүлэх, үр дүнг тооцон ажиллах	Хууль тогтоомж, шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь	100%	100%	Өөрийн нэр дээр цохогдон ирсэн хугацаатай 8ш албан бичгийг шаардлагын дагуу боловсруулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Мөн сар бүрийн орлогын мэдээ болон шилэн дансны мэдээлэл, СЗХ-д хүргүүлдэг зохицуулалттай салбарын мэдээ судалгаа болон Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн нэгдсэн бүртгэлийн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.	2025-01-01 2025-06-05	100%
---	--	---	------	------	---	--------------------------	------

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 2.1 Үндэсний бичгийг гүнзгийрүүлэн судлах, сургалтанд хамрагдах	Үндэсний бичгийн чадвар дээшилнэ.	60%	80%	Монгол бичгийн гарын авлага цахим хуудсыг даган цахим сургалтанд хамрагдаж байгаа. Мөн үндэсний бичгийн түвшин тогтоох шалгалт өгсөн.	2025-01-01 2025-06-05	100%
2.	Арга хэмжээ 2.2 Цахим санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэгээ дээшлүүлж цахим сургалтанд хамрагдах	Цахим санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг дээшилсэн байна	50%	80%	4 сарын 17-19-ны өдрүүдэд СЗХ-оос зохион байгуулсан Бондын зах зээл сэдэвт уулзалт хэлэлцүүлэгт амжилттай оролцсон	2025-01-01 2025-06-05	100%
3	Арга хэмжээ 2.3 Байгууллага хамт олноос зохион байгуулах сургалт, арга хэмжээнд тогтмол оролцох	Цаг үеийн мэдээллээс хоцрохгүй байна	100%	100%	Байгууллага хамт олны зүгээс зохион байгуулж байгаа сургалт, арга хэмжээнд тогтмол оролцон мэдээ мэдээлэл авч байгаа.	2025-01-01 2025-06-0	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

С.Оюундолгор

(Огноо)